



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/74

Номгон

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 59.1.5, 59.1.23, 66.1, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, 2023 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн Бүгд Найрамдах Хятад ард Улсын Гансу мужийн Жючуан хот болон Монгол улсын Баянхонгор аймгийн Баянхонгор хот хоорондын нөхөрсөг хот байгуулах санамж бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Санамж бичигт дурдсан цөлжилтийн эсрэг, амь ахуйн орчин, эрчим хүчний салбарын хамтын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулахыг Нийгмийн бодлого, хүн амзүйн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Сувданцэцэг)-д даалгасугай.

2.Арга хэмжээнд зарцуулагдах шатахууны зардалд 800.000 (Найман зуун мянга)-н төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Б.Цэрэннадмид)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Оюун-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Г.ЭНХБАЯР

621010949